



БАТАЛГААТАЙ МЭДЭЭЛЭЛ АМЬДРАЛЫГ АВАРНА

ГАРЫН АВЛАГА

- Цахим орчин дахь үе тэнгийн дээрэлхэлтээс хэрхэн хамгаалах вэ?
- Цахим орчин дахь худал мэдээлэлтэй хэрхэн тэмцэх вэ?

2023 он



Reliable
information
saves lives



Энэхүү гарын авлагыг ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн холбооны яамны дэмжлэгтэйгээр Дойче Велле Академи, Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл хамтран хэрэгжүүлж буй “Баталгаатай мэдээлэл амьдралыг аварна” төслийн хүрээнд “ССС баг - II” бэлтгэв. Мэдээлэл нь бүтээгчийн байр суурийг илэрхийлж буй болно.

Агуулгыг гаргасан: Б.Батзаяа, Ц.Чимэддондог

Эмхэтгэсэн: А.Наранцацрал

Хянасан: Н.Ганчимэг

Багийн гишүүд: Д.Ариунзаяа, П.Амгаланбаяр, Н.Батболд, Б.Батцэнгэл, Д.Дагийсүрэн, М.Мөнхзул, А.Наранцацрал, Ч.Отгон, Ч.Энхцэцэг

Хамтран ажилласан: Нийслэлийн Ерөнхий боловсролын 37 дугаар сургууль, Би CyberCool аян



Сургагч багш: Б.БАТЗАЯА

**ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ҮЕ
ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТЭЭС
ХЭРХЭН ХАМГААЛАХ ВЭ?**

ДЭЭРЭЛХЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?



- Санаатайгаар хохироох, гэмтээх сэдэлтэй
- Давтамжтай, давтагдах магадлалтай
- Хүчний тэнцвэргүй түрэмгий зан, үйлийг хэлнэ.

ДЭЭРЭЛХЭЛИЙН ТӨРӨЛ



Бие махбодын



Аман



Харилцааны




Цахим

ОРОЛЦОГЧИД



ХЭРХЭН ЗОГСООХ ВЭ?



- Ойр орчимд байгаа том хүнд хэлэх
- Ажиглагч хүүхэд аврагч болох
- Дээрэлхүүлж байгаа хүүхдэд чиний буруу биш гэдгийг ойлгуулж найзалж нөхөрлөөрэй.

ЦАХИМ ДЭЭРЭЛХЭЛ



Цахим дээрэлхэл нь цахим төхөөрөмж буюу гар утас, компьютер ашиглан мессеж, чат, тоглоом, олон нийтийн сүлжээг ашиглан айлган сүрдүүлэх, ичээх, нийгмээс тусгаарлах, нэр хүндэд халдах, нөхөрлөлийг үгүй хийх, зовоох зорилготой.

Жишээ нь:

- Групп чатаас хасах
- Өмнөөс нь цахим хаяг нээж бусдыг дээрэлхэх
- Цахим хаягийнх нь нууц үгийг олж аваад өмнөөс нь доог тохуу болгох пост хийх
- Мийм хийж тараах
- Ихэвчлэн хувь чат илгээж удаан хугацааны турш айлган сүрдүүлэх
- Үерхэж, найзалж байсан нэгнийхээ итгэж ярьсан зүйл, илгээсэн зургийг цааш нь ярих, нийгмийн сүлжээгээр тараах
- Хошигнох /цахимаар хошигнохоор тухайн хүүхэд чиний сэтгэл хөдлөлийг ойлгохгүй өнгөрөх магадлалтай/
• Бусдыг дээрэлхэж буй постыг цахимаар тараах



ЦАХИМ ДЭЭРЭЛХЛЭЭС ХЭРХЭН ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ ВЭ?



- Танихгүй хүнээс найзын хүсэлт авахгүй байх.

- Мэдэхгүй хүмүүсээ найзаасаа хасах.

- Аюултай эсвэл жийрхмээр хүмүүст таны профайл болон хувийн мэдээлэл харагдахгүй байхаар тохиргоогоо хийх.



- Цахим орчинд өдөөн хатгасан, дуулиан шуугиан тарьсан, цочроосон үг хэллэг бүү ашиглаарай.

Тиймэрхүү төрлийн зураг, пост шэйрлэхгүй байх.

- Фэйсбүүк хаягныхаа нууц үгсээ тогтмол сольж, хакердуулсан профайлуудыг нэн даруй устгах.





- Цахим дээрэлхэлд өртсөн тохиолдолд тухайн пост, мессеж үйлдэлд хариу өгөх, адилхан хариу арга хэмжээ авахгүй байх.



- Хамгаалалт муутай, хувийн мэдээлэлд хялбар нэвтрэх, танихгүй хүмүүсийн хоорондын харилцааг дэмжих сайт, сүлжээ, программаас зайлсхийх.



- Зураг, бичвэр, мэдээллийг нийтэлж, олон нийтэд түгээхээс өмнө тухайн зураг, пост, мэдээлэлд дурдагдсан хүн зөвшөөрсөн эсэхийг баталгаажуулах, зөвшөөрөл авах.



- Худал мэдээлэл түгээх замаар хандалт авах зорилготой сайтуудыг дагахгүй, мэдээллүүдийг шэйрлэхгүй байх.

- Хэзээ ч болохгүй! Чат, мессежээр +18 сэдэвтэй мессеж бичилцэх, нүцгэн зургаа найз охин, залуу болон бусад найз нөхдөдөө илгээхгүй байх. Хэзээ нэгэн өдөр та хоёр салбал тухайн зургийг өөр ямар нэгэн зүйлд ашиглах, алдах вий.



ДАРААХ 3 ЗАРЧМЫГ БАРИМТЛААРАЙ



“ЭЭЖ”

Ээж, аав эсвэл асран хамгаалагчтайгаа хуваалцахыг хүсэхгүй байгаа гэрэл зураг, киног бүү нийтэл, бүү хуваалц!



“ҮҮРД МӨНХӨД”

Онлайнаар оруулсан бүх зүйл чинь үүрд мөнхөд цахим орчинд хадгалагдах болно гэж бодоорой!



“ХУВИЙН НУУЦЛАЛ БАЙХГҮЙ”

Цахим орон зайд хувийн мэдээллээ оруулахаас татгалзаарай. Хүн бүр таны тухай мэдээлэл авах боломжтой гэж бодоорой!

СӨРӨГ ЗҮЙЛИЙГ ӨНГӨРҮҮЛ



Интернэт орчинд маш олон сөрөг зүйлс, муухай сэтгэгдлүүд байдаг.

**ТЭДГЭЭРИЙГ УНШИЖ
ХАРИУ БИЧИХ
ШААРДЛАГАГҮЙ.**



Бас чамд таалагдахгүй байлаа гээд сөрөг коммент бичиж шэйрлээд хэрэггүй. Сэтгэгдлүүд нь чи тэр хүн рүү хараад муухай үг хэлж байгаатай адил мэдрэмж огдог.

**СӨРӨГ ЗҮЙЛСИЙГ ӨНГӨРӨӨГӨӨД
ТООХГҮЙ ХАЯХ ХЭРЭГТЭЙ.**



Аливаа постыг шэйрлэх, бусад руу илгээхээсээ өмнө

САЙН БОД.

УУРТАЙ ҮЕДЭЭ ХЭЗЭЭ Ч БҮҮ ПОСТ ХИЙ, СЭТГЭГДЭЛ БИЧ!



Постлох, илгээх, шэйрлэх, коммент бичихээсээ олно бичсэн зүйлээ дахиад нэг уншаарай.

Тэгээд энэ мессеж, сэтгэгдлийг чамд хэн нэгэн хүнээс ирж байна гэж тосоол. Сэтгэл өвтгөхөөр байна уу?



- Нэгнийгээ муулсан, тааламжгүй чатаас гарах
- Хэт маазрах, шооч байх хэрэггүй
- Хэт маазрах, шооч байх нь цахим дээрэлхлийг үүсгэж, дэвэргэж байдаг учраас болгоомжтой хандаарай.

ЦАХИМ ДЭЭРЭЛХЛИЙГ ХЭРХЭН ТАСЛАН ЗОГСООХ ВЭ?

- Хамгийн эхний алхам: Тэр зүйлийг шэйрлэхгүй байгаарай
- Report хийх, найзуудаасаа report хийж өгөхийг хүсээрэй
- Итгэлтэй том хүнээс тусламж аваарай
- Цахим дээрэлхэл үйлдсэн хүүхэд санамсаргүйгээр үйлдсэн байж болох тул тухайн хүүхдэд хувийн чатаар найрсгаар сануулаарай.



ЧИ БОЛОН ЧИН ИЙ НАЙЗ ЦАХИМ ДЭЭРЭЛХЭЛД ӨРТСӨН БОЛ ЯАХ ВЭ?



- Энэхүү үйлдэл нь буруу зүйл. Дээрэлхэл үйлдээд байгаа гэдгийг нь хэлэх
- Тухайн зураг постыг report хийх
- Дээрэлхээд байгаа хүнийг блок хийх
- Итгэлтэй том хүндээ хэлэх /Эцэг эх, багш, сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан гэх мэт/
- Screen shot хийж, баримтжуулж хадгалах
- Цагдаад мэдэгдэх
- Цахим ертөнцөөс түр холдон агаарт гарах, дуртай зүйлдээ анхаарлаа хандуулах



Цахим орчинд хийж байгаа зүйл цахим ул мөр үлдээж байдаг. Цахим ул мөр ирээдүйд сургууль, ажилд ороход чинь багадаа чамайг ямар хүүхэд байсан, цахим орчин хэрхэн ашигладаг байсан, өмнө нь хүүхэд дээрэлхэж байсан эсэх нь 10-20 жилийн дараах ирээдүй буюу их сургуульд орох, тэтгэлэг авах, ажилд ороход чинь нөлөөлнө.

Цахим орчинд муу ул мөр үлдээвэл ирээдүйд муугаар нөлөөлөх юм шүү!




СУРАГЧДЫН ЗӨВЛӨГӨӨ



37-р сургуулийн 8-р ангийн сурагч Б.Баярчимэг:

Танд чухал зүйл биш мэт боловч гадуурхагдаж байгаа хүүхдийн оронд өөрийгөө тавиад үзээрэй. Хүн бүхэнд дутагдал, бас давуу тал бий. Хамтдаа үе тэнгийн дээрэлхэлт, цахим орчны ялгаварлан гадуурхалтаас сэргийлцгээе!




37-р сургуулийн 9-р ангийн сурагч М.Хулан:

Үе тэнгийн дарамтад байдаг хүүхэд оороо ч дарангуйлагч болох магадлал их. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд тухайн хүүхэд сул тал дээрээ төвлөрөлгүй, оортоо итгэлтэй байх, өөрийн үнэлэмж нь ондор байх нь чухал.



37-р сургуулийн 7-р ангийн сурагч Н.Батнасан, С.Түвшинбаяр:

Дарамтлуулж, шоовдорлуулсан ч хэнд хандахаа мэдэхгүй бол сэтгэл санаагаар уналгүй тайван байх хэрэгтэй. Дээрэлхэлтийг тэвчих, түүнээс айж ичиж, нууцлах хэрэггүй. Итгэлийг чинь даах том хүн буюу эцэг эх, ах эгч, багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчээс тусламж, зөвлөгөө аварай.





Сургагч багш: Ц.ЧИМЭДДОНДОГ

**ЦАХИМ ОРЧИН ДАХЬ
ХУДАЛ МЭДЭЭЛЭЛТЭЙ
ХЭРХЭН ТЭМЦЭХ ВЭ?**

ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?



Худал мэдээлэл гэж бусдыг төөрөгдүүлэх, буруу мэдээлэл өгөх зорилгоор санаатай бүтээсэн, боловсруулсан буруу ташаа мэдээ, мэдээлэл, зураг видеог хэлдэг.



Үнэн бодит мэдээллийг бусдыг хууран мэхлэх зорилгоор мушгин гуйвуулах ч үүнд багтана. Хүүхдүүд мэдээллийн үнэн, бодит эсэхийг нягталж, хуурамч мэдээ, мэдээллийг ялгаж, таньж сурах нь чухал юм. Ингэснээр буруу ташаа мэдээлэлд автахгүй байх, санамсаргүйгээр бусадтай хуваалцахгүй байх дадалтай болдог.

ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ЯМАР ХОР УРШИГТАЙ ВЭ?

Хүүхдүүдийн мэдээллийн тухай боловсрол сул байвал худал мэдээлэл хурдан тархдаг. Мэдээллийн боловсролоо сайжруулж, юу үнэн, юу худал болохыг ялгаж сурах хэрэгтэй. Нэгэнт цацагдсан худал мэдээлэл үнэн бодит мэдээллээс илүү олон хүнд хүрч цахим сүлжээнд гүн нэвчдэг.



ХУДАЛ МЭДЭЭНИЙ ХОР УРШИГ


Цочролд ордог

- Тухайн мэдээлэлд итгээд шийдвэр гаргалаа гэхэд тэр шийдвэр буруу байгаад хохирч болзошгүй. Худал мэдээллийн хор уршиг үүнд оршдог.
- Худал мэдээллээс болж хохирсон хүн сэтгэл санааны гүн цочролд ордог.
- Ихэнх худал мэдээлэл хүний анхаарал татах зорилготой цочирдом гарчиг, агуулгатай байдаг.



Ичгүүртэй байдалд ордог

- Худал мэдээллийг хошигнол тоглоом болгож, эсвэл улс төрийн байр суурийг дэмжих зорилгоор зориудаар зохиож хүмүүст түгээдэг. Мөн алиа хошин яриаг үнэн бодит мэт хүлээж аваад бусадтай хуваалцдаг. Хуваалцсаныхаа дараа худал нь мэдэгдэхэд ичгүүртэй байдалд орж болзошгүй байдаг.




Зан чанарт нөлөөлдөг

- Худал мэдээлэл нь хүний итгэл үнэмшил, бодол санаа шийдвэрт нөлөөлөх, буруу ташаа зүйлд итгүүлэх эцсийн зорилгыг агуулдаг. Энэ нь хүүхдүүдийн сэтгэхүй, биеэ авч явах байдалд нөлөөлнө гэдэгт анхаарах хэрэгтэй.
- Худал мэдээллийг нягтлахгүйгээр түгээх, уншиж, үзэж сонсох нь найзуудынхаа болон өөрсдийнхөө зан араншин, итгэл үнэмшлийг өөрчлөх аюултай.




ХУДАЛ МЭДЭЭГ ХЭРХЭН ТАНИХ ВЭ?




1. Мэдээллийн эх үүсвэрийг нягтал
2. Агуулгыг нягтал
3. Домэйн хаягийг нягтал
4. Дурдагдсан бүх эх сурвалжийг нягтал
5. Мэдээлэл тэнцвэртэй байна уу гэдгийг харах
6. Баримт уу, эсвэл үзэл бодол уу гэдгийг ялгах

ХУДАЛ МЭДЭЭЛЭЛТЭЙ ХЭРХЭН ТЭМЦЭХ ВЭ?



REPORT



ХЭРХЭН НЯГТЛАХ ВЭ?

Мэдээлэл нягтлах зарим арга

www.



- **www.images.google.com** сайтаас зургийг хайж нягталж шалгах боломжтой
- **www.yandex.ru** /газар зүйн байршлын онцлогоос шалтгаалаад монгол зургууд олох боломжтой/
- **www.tineye.com** /гадаадаас Монгол руу орж ирсэн хуурамч зургийг олох боломжтой/
- **www.baidu.cn** /Азийн хуурамч мэдээлэл дагуулсан зургийг олох боломжтой/

Эдгээр сайтууд зургийн анхны эх сурвалж нь аль сайтад байгааг олж өгдөг.

- Мөн манай улсын баталгаатай мэдээллийн сайтуудаас тухайн мэдээллийг нягтлах боломжтой
- **www.whois.com** нь хуурамч эсвэл жинхэнэ вэб сайт эсэхийг шалгадаг сайт юм. Тухайн сайтын албан газар хаана байрладаг, эзэн нь хэн зэрэг мэдээллүүдийг авах боломжтой.

ХУДАЛ МЭДЭЭЛЛЭЭС БОЛЖ ХЯМАРСАН НАЙЗАА ТАЙВШРУУЛААРЙ, ХҮҮХДҮҮД ЭЭ!




Тоолж баршгүй их мэдээллийн эринд амьдарч буй бидний хувьд зайлшгүй эзэмшвэл зохих нэгэн шинэ чадвар бол мэдээллийн боловсрол юм. Аливаа мэдээллийг уншиж, сонсоод шууд итгэлгүйгээр үнэн, худал эсэхийг нягталж байх, тухайн мэдээллийг цааш дамжуулснаар гарах үр дагаврыг тооцож байх нь чухал билээ.



**Цахим орчинд эелдэг байцгаая!
Баталгаатай мэдээлэл амьдралыг аварна.**

СУРАГЧДЫН ЗӨВЛӨГӨӨ



37-р сургуулийн 6-р ангийн сурагч А.Ану:

Хүүхдүүд ээ, цахим орчныг бага ашиглаж, гэр бүлтэйгээ ойр дотно байгаарай!



37-р сургуулийн 8-р ангийн сурагч Г.Шинэбаяр:

Хүүхдүүд ээ, худал мэдээлэлд битгий автаарай! Янз бүрийн линк рүү орохгүй байх хэрэгтэй. Худал сайтанд бүү итгээрэй.



Дуучин С.Гантогоо:

Баталгаагүй мэдээлэлд битгий итгээрэй, эх сурвалжийг нь сайн шалгаж байгаарай.



**БАТАЛГААТАЙ МЭДЭЭЛЭЛ
АМЬДРАЛЫГ АВАРНА**